



## **“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 03 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар ТУЗ 2021-03/02

Улаанбаатар  
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1, 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Жуулчин Дюти Фрий ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.1, 7.2, 7.3 дахь хэсэг, 8-р зүйлийн 8.9.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04-р сарын 26-ны өдрийн Даваа гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Таван Богд Групп”-ийн төв байрны, 2,5-р давхарт байрлах хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

- 2.1 Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах,
- 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах
- 2.3 Компанийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах,
- 2.4 Компанийн 2020 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах,
- 2.5 Компанийн 2021 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах

3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт №1-ээр баталж, 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хавсралт №2-оор баталж 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй компанийн үйл ажиллагаа хариуцсан менежер Э.Энхбаяр /Утас: 94990778, [jdf-operations@tavanbogd.com](mailto:jdf-operations@tavanbogd.com)/ --тай холбогдон танилцах боломжтойг болохыг мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байхаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 17:00 цаг хүртэл тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Т.Солонго, Г.Болорцэцэг, Няглан бодогч Б.Алтанцэцэг нарыг тус тус томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаярыг томилон, хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг зөвшөөрсүгэй.

12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нэхцэл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэх ажлыг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр, үйл ажиллагаа хариуцсан менежер Э.Энхбаяр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА .....

Ц.БААТАРСАЙХАН

